БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 04 дүгээр сарын 14 Дугаар 41 Улаанбаатар хот

Хамтарсан багийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь хэсэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны А/173, А/251, А/380 дугаар тушаалыг тус тус үндэслэн Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит гуравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Баянзүрх дүүргийн хороо тус бүрийн Хамтарсан багийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Хууль, тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлж, ажиллахыг Хамтарсан багийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

3.Хамтарсан багийн үйл ажиллагааны болон санхүүжилтийн зарцуулалтын тайланг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанд сар бүр ирүүлэхийг Хамтарсан багуудад даалгасугай.

4.Тогтоол батлагдсантай холбогдуулан Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 30 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

5.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (А.Уранбилэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА Ч.МЭНДСАЙХАН

Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 41 дүгээр тогтоолын хавсралт

Баянзүрх дүүргийн хороодын
Хамтарсан багийн бүрэлдэхүүн

Хамтарсан багийн ахлагч:	Хорооны Засаг дарга
Гишүүд:	Хорооны Нийгмийн ажилтан
	Хорооны Цагдаагийн алба хаагч
	Сургуулийн Нийгмийн ажилтан
	Өрхийн Эрүүл мэндийн Нийгмийн ажилтан
	Халамжийн Нийгмийн ажилтан
Нарийн бичгийн дарга:	Хүүхэд, гэр бүлийн Нийгмийн ажилтан
Шаардлагатай бол:	Цэцэрлэгийн арга зүйч
	Өрхийн Эрүүл мэндийн төвийн эмч
	Хүүхэд, гэр бүлд үйлчилгээ үзүүлдэг Төрийн бус байгууллагын төлөөлөл